



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 04 өдөр

Дугаар A/339

Мөрөн сум

Барилга байгууламжийг хүлээн авч,  
ашиглалтад оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6 Засгийн газрын 2021 оны 212 дугаар толтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын Дархадын хотгорын цөлжилтийг бууруулах, Цойцон нуурыг нөхөн сэргээх ажлын хүрээнд холбогдох барилга байгууламж (далан суваг)-ийг хүлээн авч ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Г.Ням-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн архивын тасгийн Сан хөмрөгийн эрхлэгч)

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)

Б.Даваасүрэн (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Л.Бямбасүрэн (Аймгийн онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч)

Д.Дамцагдулам (Байгаль орчин аялал жуулчлалын газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Өнөрбаяр (Дэлгэрмөрөн Шишхэд голын сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн)

Ж.Улаанбаатар (“Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв “ОНӨААТҮГазрын хяналтын инженер)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Б.Батзаяа (“Престиж инженеринг” ХХК-ийн ахлах инженер)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:  
Н.Мөнхжин ("Престиж инженеринг" ХХК-ийн инженер)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:  
Д.Отгонбаяр (Ренчинлхүмбэ сумын Засаг дарга )

Х.Мөнх-Эрдэнэ (Ренчинлхүмбэ сумын Засаг даргын орлогч)

М.Баясгалан (Ренчинлхүмбэ сумын байгаль орчны байцаагч)

Д.Пүрэвсүрэн (Ренчинлхүмбэ сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч)

Ш.Одгэрэл (Ренчинлхүмбэ сумын 2 дугаар багийн Засаг дарга)

Б.Баасан (Ренчинлхүмбэ сумын 2 дугаар багийн иргэн)

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Баасанжав (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Барилга байгууламж хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилга байгууламж хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.



ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН